Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЦЭНДСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **Зорилт 1. “Салбарын хууль тогтоомж, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх”** | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Төрийн хяналт шалгалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, аргачлал, зааврууд шинэчлэн боловсруулж, батлуулахад санал өгөх. | Шинээр боловсруулсан эрх зүйн баримт бичгийн тоо | “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон.<br><br>“Хяналт шалгалтын нийтлэг журам” шинээр батлагдсан. | Хууль, ЗГ-ын тогтоолд нийцүүлэн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх 1 эрх зүйн баримт бичигт санал хүргүүлнэ. | 2023 онд хийгдсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”-д өөрчлөлт оруулахаар 1 саналыг ЗТЯ-ны СХГ-т уламжилсан. | 2024-02-05-аас 2024-02-7-нд | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Автотээврийн салбарын эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулахад санал өгөх. | Шалгуур үзүүлэлтийн тоо | 2023 онд 2 санал хүргүүлсэн. | Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулахад 1 санал өгсөн байна. | Эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох талаар 1 санал хүргүүлсэн. | 2024.10.29 - 2024.10.29 | 100 |
| 3. | Арга хэмжээ 1.3. Автотээврийн салбарын байгууллагуудын обьект, үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, ЗТЯ-ны Салбарын | -Эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллага, 10-аас багагүй. | 2023 онд нийт 90 обьектод эрсдлийн үнэлгээ хийсэн.<br><br>-ЗТЯ-нд хяналт | Нийт 10-аас багагүй обьектод эрсдлийн үнэлгээ хийсэн байна. | 2024 онд 52 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. Их эрсдэлтэй үнэлэгдсэн 10 объектод 2025 шалгалт хийхээр төлөвлөгөө боловсруулан ЗТЯ-ны СХГ-т хүргүүлж, төлөвлөгөөг батлуулсан. Үйл ажиллагаа явуулахаа | 2024.10.15 2024.10.22 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтын газарт хүргүүлэх. | ЗТЯ-ны СХГ-т хяналт шалгалтын төлөвлөгөөг хүргүүлсэн байна. | шалгалтын төлөвлөгөөг хүргүүлсэн | ЗТЯ-ны СХГ-т ирэх оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж хүргүүлсэн байна. | больсон, эзэн, хаяг тодорхойгүй болсон авто үйлчилгээ эрхлэгч /дугуй засварын үйлчилгээ/ обеъктуудад эрсдэлийн үнэлгээ хийлгүй, объектын жагсаалтаас хасч, шинээр үйл ажиллагаа эрхлэж эхэлсэн объектуудыг бүртгэж, эрсдэлийн үнэлгээ хийсэн. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Автотээврийн салбарын хяналт шалгалтад ашиглах хяналтын хуудсыг боловсруулахад санал өгөх | -Хяналтын хуудасны тоо<br>-Саналын тоо | 9 хяналтын хуудсанд өөрчлөлт оруулахаар 5 санал өгсөн | 3-аас доошгүй санал хүргүүлнэ. | Салбарын хяналт шалгалтад ашиглах 2 хяналтын хуудсыг боловсронгуй болгоход 9 санал хүргүүлсэн. | 2024.01.11 - 2024.10.23 | 100 |
| 5. | Арга хэмжээ 1.5. Хяналт шалгалтын хяналтын хуудсыг цахимжуулах хэрэглээний /application/ нэвтрүүлсэн программыг бүрэн ашиглах. | -Хяналт шалгалтад ашигласан хяналтын хуудсыг 100 хувь цахимд бүртгэсэн байна. | Эхлэх шатанд | -Хэрэглээний /application/ программыг ашиглаж, хэрэглэж эхэлнэ. | 2024 онд хяналт шалгалт хийхээр батлагдсан 10 объектод төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтын баримт бичгийг шилэн хяналтын системд бүрэн оруулж "Хяналт хийсэн" төлөвт шилжүүлсэн. Урьдчилан сэргийлэх 1 шалгалт, төлөвлөгөөт бус 3 шалгалтуудын мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулж, хэрэглээний программыг бүрэн ашиглаж байна | 2024-05-31 – 2024-12-10 | 100 |
| **Зорилт 2."Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аюулгүй байдлыг хангах, ослоос урьдчилан сэргийлж, илэрсэн зөрчил,дутагдлыг арилгуулах."** | | | | | | | |
| 6. | Арга хэмжээ 2.1. Их дунд эрсдэлтэй үнэлгдсэн 10 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | 10 обьектод хяналт шалгалт хийсэн байна | 2023 онд 10 обьектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. | 10 обьектод хяналт шалгалт хийсэн байна. | Тайлант хугацаанд 10 объектод шалгалт хийхээр төлөвлөсөн бөгөөд орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг 5, аюултай ачаа (баллонд шахсан хий) тээвэрлэгч 2 аж ахуйн нэгжийн 4 объект, нийт 9 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. Орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг 1 аж ахуйн нэгж (Болор шил ХХК. Арвайхээр – Төгрөг чиглэлд) тээвэрлэлтийн гэрээг сунгаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байна. 2024 онд хийх төлөвлөгөөт шалгалт бүрэн хийгдсэн. | 2024-04-16 – 2024-12-02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 2.2. Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагад өгсөн албан шаардлагын хүрээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. | Өгсөн албан шаардлагын хүрээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ. | 2023 онд 3 гүйцэтгэлийн хяналт хийсэн. | Өгсөн албан шаардлагын хүрээнд | Тайлант хугацаанд нийт 11 албан шаардлага, 1 акт боловсруулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн. Үүнээс 4 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн албан шаардлагын биелэлтэд гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Албан шаардлагын хэрэгжилт 72.3%-тай байна. Шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага байхгүй учир нэмэлт ямар нэг баримт бичиг гаргаагүй. | 2024-09-25 – 2024-11-25 | 100 |
| 8 | Арга хэмжээ 2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгалтын хувь | 2023 онд төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчилд шийтгэлийн арга хэмжээ тооцож, албан шаардлага хүргүүлэн зөрчлийг 100% арилгуулж ажилласан. | Өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна. Зөрчил арилгалтын хувь 70-аас багагүй байна. | Иргэнээс 1, аж ахуйн нэгж, байгууллага (ЭБЦТС ТӨХК-ийн ӨВ салбар)-аас 1, Засгийн газрын 1111 төвөөс (Зам тээврийн яамаар дамжиж Баянтээг ХК-д шалгалт хийлгэх тухай) 1 нийт 3 гомдол, хүсэлт ирсэний дагуу шалгалт хийсэн. Илэрсэн зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хянан шийдвэрлэж, Баянтээг ХК-д албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Баянтээг ХК-г 1500000 төгрөгөөр торгох арга хэмжээ, 1 иргэнийг 20000 төгрөгөөр торгох арга хэмжээ, ЭБЦТС ТӨХК-ийн ӨВ салбарыг 200000 төгрөгөөр торгох арга хэмжээ тус тус тооцож ажилласан. Өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэж, холбогдох этгээдэд хариу мэдэгдэж ажилласан. Өргөдөл гомдлын дагуу хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн 82.3%-ийг арилгуулсан байна. | 2024-01-01 – 2024-12-02 | 100 |
| 9 | Арга хэмжээ 2.4. ЗТЯ-ны СХГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу авто тээврийн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | Шалгалт хийсэн обьектын тоо Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь | ЗТЯ-ны СХГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн | Удирдамжийн хүрээнд шалгалтыг бүрэн хийсэн байна | СХГ-ын даргын баталсан 04/02 дугаартай удирдамжийн хүрээнд Хужирт бүтээмж ХХК-ийн захиалгат тээвэрлэлтийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн. Тус компанийн нэр дээр бүртгэлтэй БНСУ-д 2008, 2009 онуудад | 2024-04-18 – 2024-05-22 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Арга хэмжээний биелэлт | | | үйлдвэрлэгдсэн 2ш автобус нь тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангахгүй байгаагаас зорчигчийн амь нас, эрүүл мэндэд аюул хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлж байгаа тул улсын байцаагчийн актаар 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглахыг бүрмөсөн зогсоож, бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулж ажилласан. Акт, албан шаардлагын биелэлт 100% хэрэгжсэн. | | |
| 10 | Арга хэмжээ 2.5. Зөрчлийн хэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган шийдвэрлэх. | -Зөрчил шалган шийдвэрлэсэн тоо, хэрэг шийдвэрлэлтийн хувь | 2023 онд 5 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 380000 төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ тооцож бүрэн барагдуулсан. | Хууль тогтоомжийн хүрээнд зөрчлийг шалган шийдвэрлэнэ. | Тайлант хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 3 удаа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 2 аж ахуйн нэгж, байгууллага, 1 иргэнд нийт 1720000 төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ тооцсон. Зөрчлийн хэргийг прокурорт хянуулж, холбогдох этгээдэд хариу мэдэгдэж ажилласан. Хэрэг шийдвэрлэлт 100%, торгуулийн мөнгийг Төрийн сангийн 100100000988 тоот дансанд бүрэн төвлөрүүлсэн. | 2024-01-02 – 2024-12-02 | 100 |
| **Зорилт 3. Салбарын яам, салбарын хяналтын газар, холбогдох бусад газраас зохион байгуулсан сургалт зөвлөгөөд хамрагдах** | | | | | | | |
| 11 | Арга хэмжээ 3.1 ЗТЯ, Салбарын хяналтын газраас зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд хамрагдах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Арга хэмжээтэй холбоотой үйл ажиллагаа зохион байгуулсан тоо | Хяналтын улсын байцаагч 1 удаагийн цахим сургалтанд хамрагдсан. | Зохион байгуулсан тоогоор | Шилэн хяналт ашиглалтад орж байгаатай холбогдуулан Салбарын хяналтын газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан. | 2024-05-30 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Монгол Улсад цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг улирал бүр ЗТЯ-нд хүргүүлэх | Холбогдох мэдээлэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга улирал бүр ЗТЯ-нд хүргүүлсэн байх | - | Холбогдох мэдээлэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга улирал бүр ЗТЯ-нд хүргүүлсэн байх | Арвайхээр хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэгч Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын захиралд хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан автомашин ашиглах бэлтгэл арга хэмжээг авч ажиллах тухай ХБТХОХ-ийн даргын 3-3/279 тоот албан бичгийг хүргүүлсэн. Арвайхээр хотын нутаг дэвсгэрт, улсын чанартай А0301 дугаартай авто замын дагуух байрлан үйл ажиллагаа явуулдаг Номин бизнес клуб, баруун бүс ХХК-ийн Арвайхээр салбарт болон Алтан жолоо трейд ХХК-ийн Сансар худалдааны төвийн 62 дугаар салбарт гадна зогсоолдоо цахилгаан автомашин цэнэглэгч суурилуулах тухай ХБТХОХ-ийн даргын 3-3/277, 3-3/278 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн. Арвайхээр хотын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 3000 мкв талбай бүхий газрыг цахилгаан автомашины түргэн цэнэглэгч төхөөрөмж суурлуулах зориулалтаар тусгуулаад байна. Тухайн газрыг дуудлага худалдаагаар эзэмшигчийг тодруулах ажил зохион байгуулагдаж байна. Хийгдэж байгаа ажил үйлчилгээний талаарх мэдээллийг улирал бүр ЗТЯ-нд хүргүүлж ажилласан. | 2024-03-27 – 2024-12-02 | 100 |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.Шинээр гарсан болон өөрчлөлт орсон хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг судлах | хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг судлах | 100% | 50% | Зөвшөөрлийн тухай хууль, Автотээврийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг судалж, орон нутгийн болон хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх болсон тухай холбогдох мэдээллийг аймгийн Автотээврийн төвд 3-3/280 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хотын доторх болон орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад 2024 оны 10 дугаар сарын 15-аас тухайн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх болсон талаар мэдээлэл өгсөн. Одоогийн байдлаар орон нутгийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгч 1 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ ирүүлээд байна. | 2024-04-09 – 2024-12-02 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2. Холбогдох бусад газраас зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд хамрагдаж мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх | мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх | 100% | 50% | Даян дэлхийн ногоон хөгжлийн институттэй хамтран хэрэгжүүлж буй "Орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах нь" төслийн хүрээнд явуулсан бүсчилсэн сургалт хамрагдсан.<br>Шилэн хяналт ашиглалтад орж байгаатай холбогдуулан зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.<br>Удирдлагын академиас | 2024-04-10 – 2024-05-26<br>2024-05-30<br>2024-11-04 – 2024-11-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулагдсан “Хөгжлийн бодлого, хэрэгжилт-сэтгэлгээний өөрчлөлтийн хэрэгцээ” сургалтад хамрагдсан.<br>“Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтад хамрагдсан. | 2024-11-14,15 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Автотээврийн хяналтын улсын байцаагч ............................ / Б.Цэндсүрэн / 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр